



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 08 өдөр

Дугаар Б/08

Батноров сум

Н.Энхтайванг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.12, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Засгийн газрын 2024 оны "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай" 82 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/568 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батноров сумын Хог хаягдлын олон нийтийн байцаагчаар Наваашарав овогтой Энхтайванг 2024 оны 10 дугаар сарын 08-ын өдрөөс эхлэн томилон ажиллуулсугай.

2. Хог хаягдлын олон нийтийн байцаагч Н.Энхтайваны үндсэн цалинг ТҮ-1 зэрэглэл 900.000 (Есөн зуун мянган) төгрөгөөр цалинжуулж, холбогдох журмын дагуу гэрээ байгуулан ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Борчулуун), Нягтлан (Б.Энхжаргал) -д нарт үүрэг болгосугай.

3. Байгууллагын үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйг чанд мөрдөн сумын хог хаягдлын менежментийг сайжруулан холбогдох журмыг дагаж мөрдөн хариуцсан ажилдаа хичээл зүтгэлтэй ажиллахыг (Н.Энхтайван)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Ган-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР

230423308